

МОНГОЛЫН ЭХ БАРИГЧДЫН НИЙГЭМЛЭГИЙН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад байгуулагдсан Монголын эх баригчдын нийгэмлэг (цаашид “Нийгэмлэг” гэх) нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуульд заасны дагуу өөрийн дүрмийг батлав.
- 1.2 Нийгэмлэг нь эх баригчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус, төрийн бус байгууллага болно.
- 1.3 Нийгэмлэг нь хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

ХОЁР. НИЙГЭМЛЭГИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

- 2.1 Нийгэмлэгийн оноосон нэр:
Монголоор: Монголын Эх Баригчдын Нийгэмлэг
Англиар: Mongolian Midwives Association гэж нэрлэнэ.
- 2.2 Нийгэмлэгийн оршин байгаа газар, албан ёсны хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 4 хороо,
Намнансүрэнгийн гудамж, Нийслэлийн Хүрээ амаржих газар
Утас: 99165858; 88280958
- 2.3 Үүсгэн байгуулагдсан огноо: 2006.09.28
- 2.4 Нийгэмлэг нь удирдах зөвлөлөөс баталсан эмблем, албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тамга тэмдэг хэрэглэнэ.

ГУРАВ. НИЙГЭМЛЭГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

- 3.1 **Нийгэмлэгийн зорилго:** Нийгэмлэгийн зорилго нь эх баригчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдний мэдлэг, дадлага, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, хүн амд үзүүлэх эх барихуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, гэр бүл төлөвлөлт, нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх, эх баригчдын үйл ажиллагааг идэвхижүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.
- 3.2 **Нийгэмлэгийн зорилт:**
 - 3.2.1 Нийгэмлэгийн чадавхийг бэхжүүлэх, өргөжүүлэх;
 - 3.2.2 Монгол улсын хүн амын эрүүл мэндийг дэмжих, эх нялхас, гэр бүлийн эрүүл аж төрөх, сайн сайхан аж байдлын төлөө НҮЭМ, эсэн мэнд амаржихуйн ээлтэй тусламж үзүүлэх, үйл ажиллагааны чанар, стандартыг сайжруулах;
 - 3.2.3 Эх баригчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, цол зэрэг хамгаалах, төгсөлтийн дараах сургалтын асуудалд онцлон анхаарч,

мэргэжлийн болон удирдлагын арга зүйгээр хангах, эрдэм судлалын ажлыг өргөжүүлэх;

- 3.2.4 Нийгэмлэг нь дотоод гадаадын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтран ажиллах, түншлэлийг өргөжүүлэх, харилцахбүх байгууллагын үйл ажиллагаанд эх баригч, бага эмч нарыг төлөөлөн оролцож, дуу хоолойг идэвхитэй хүргэх.

ДӨРӨВ. НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ

- 4.1 Нийгэмлэг нь гишүүддээ үйлчилж, тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой, ашгийн төлөө бус, гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага хэлбэрээр ажиллана.
- 4.2 Нийгэмлэг нь орон нутагт өөрийн салбар нийгэмлэгтэй байна. Энэ тохиолдолд салбар нийгэмлэг нь энэ Дүрэмд нийцүүлэн өөрийн үйл ажиллагаагаа явуулна.
- 4.3 Нийгэмлэг нь өөрийн нэрийн өмнөөс гадаадын болон Монголын байгууллагатай гэрээ, хэлцэл байгуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх олж авах, үүрэг хүлээх, шүүх, арбитрын үйл ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эрхтэй.
- 4.4 Нийгэмлэг нь өөрийн хөрөнгө, дотоод, гадаадын банкинд төгрөгийн болон гадаад валютын данстай байна.
- 4.5 Нийгэмлэг нь үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод явуулж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуулиар тогтоосон хугацаанд гаргаж, гишүүддээ жилд нэг удаа тайлагнана.

ТАВ. НИЙГЭМЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 5.1 Нийгэмлэг нь дараах чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа явуулна:
- 5.1.1 Эх баригчдын ажиллах нөхцөл, цалин, тэтгэвэр, тэтгэлэг, хүний нөөцийн бусад асуудлыг шийдвэрлэхэд баримтлах ойрын болон хэтийн төлөвлөгөө, чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх;
- 5.1.2 Эх барихуйн тусламж үйлчилгээний чанарыг дээшлүүлэх чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийх, боловсролын болон мэргэжлийн цол зэрэг хамгаалахыг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын асуудалд мэргэжлийн болон удирдлагын арга зүйгээр хангах;
- 5.1.3 Олон улсын эх баригчдын нийгэмлэгийн ивээл дор нэгдэн ажиллах;
- 5.1.4 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.

ЗУРГАА. ГИШҮҮНЧЛЭЛ

- 6.1 Дор дурдсан шаардлагыг хангасан хувь хүн Нийгэмлэгийн гишүүнээр элсэж болно:
- 6.1.1 Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн Анагаах ухааны боловсрол эзэмшүүлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийг төгссөн эх баригч;

- 6.1.2 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан эх баригч;
- 6.2 Дүрмийн 6.1-д заасан шаардлагыг хангасан хувь хүн нь Нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжиж, дүрмийг зөвшөөрч байгаагаа илэрхийлэн хүсэлтээ гаргана.
- 6.3 Нийгэмлэгийн үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан гишүүн болон гишүүн бус иргэнийг “Нийгэмлэгийн хүндэт гишүүн”-д өргөмжилж болно.
- 6.4 Эх барих эмэгтэйчүүдын эмч болон бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэн, байгууллага “Нийгэмлэгийн дэмжигч гишүүн” байж болно.
- 6.5 Нийгэмлэгийн гишүүн нь аль нэг салбар нийгэмлэгт харьяалагдана.
- 6.6 **Гишүүний эрх:** Нийгэмлэгийн гишүүн дараахь эрх эдэлнэ:
- 6.6.1 Мэргэжлийн дадлага туршлага, мэдлэгээ дээшлүүлэх талаар дэмжлэг туслалцаа авах;
- 6.6.2 Судалгаа шинжилгээний ажилд оролцох, ажлын туршлага, үр дүнг хэлэлцүүлэх, нэвтрүүлэх, хэвлүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг, туслалцаа авах;
- 6.6.3 Аливаа шагналд ажил, бүтээлээ дэвшүүлэх, мэргэжлийн зэрэг ур чадвараа хамгаалах асуудлаар нийгэмлэгээс дэмжлэг авах;
- 6.6.4 Нийгэмлэгийн удирдах байгууллагад сонгох, сонгогдох сонгуульд нэрээ дэвшүүлэх, татгалзах;
- 6.6.5 Нийгэмлэгийн аль ч шатны бодлого боловсруулах, хэлэлцэхэд санал санаачлага гаргах, биечлэн оролцох;
- 6.6.6 Нийгэмлэгийн гишүүн эх баригч, бага эмч нар нь Нийгэмлэгээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон дотоод, гадаадын сургалтанд хамрагдахад давуу эрх эдлэнэ.
- 6.7 **Гишүүний үүрэг:** Нийгэмлэгийн гишүүн дараах үүрэг хүлээнэ:
- 6.7.1 Нийгэмлэгийн дүрэм бодлого, шийдвэрийг биелүүлэхийн төлөө идэвхитэй үйл ажиллагаа явуулах;
- 6.7.2 Мэргэжлийн мэдлэг, чадвар хандлагаа байнга дээшлүүлж ажиллах;
- 6.7.3 Эрхэлсэн ажилдаа дүн шинжилгээ хийх, шинжлэх ухаан, техник технологийн ололт, тэргүүн туршлага нэвтрүүлэх талаар санаачлагатай ажиллах;
- 6.7.4 Хүн амын дунд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, ялангуяа НҮЭМ, эсэн мэнд амаржихуйн чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;
- 6.7.5 Эх баригчдын мэргэжлийн эрх үүрэг, ёс суртахууны хэм хэмжээг чандлан сахих, нийгэмлэгийн нэр хүндэд харшлах суртал ухуулга хийхгүй байх;
- 6.7.6 Гишүүний татварыг тогтоосон журмаар өгч, Нийгэмлэгийн сан хөмрөгийг арвижуулах талаар дэмжлэг үзүүлэх.
- 6.8 **Гишүүнээр элсэх, чөлөөлөх, гишүүнчлэлийг сэргээх:** Нийгэмлэгт гишүүнээр элсэх, гишүүнчлэлээс чөлөөлөх, гишүүнчлэлийг сэргээх асуудлыг харьяалалын салбар нийгэмлэгээр дамжин шийдвэрлүүлнэ.
- 6.9 **Гишүүнчлэлээс чөлөөлөх:** Дор дурдсан үндэслэлээр гишүүнийг гишүүнчлэлээс чөлөөлнө:
- 6.9.1 Нийгэмлэгийн гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

- 6.9.2 Нийгэмлэгийн гишүүн нас барсан;
 - 6.9.3 Нийгэмлэгийн дүрмийг удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн;
 - 6.9.4 Нийгэмлэгийн гишүүний татварыг 2 жил дараалан төлөөгүй;
 - 6.9.5 Нийгэмлэгийн гишүүний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу үүргээ удаа дараа зөрчсөн;
 - 6.9.6 Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр хүчин төгөлдөр шийдвэрээр нотлогдсон.
- 6.10 **Гишүүнчлэлийг сэргээх**: Нийгэмлэгийн гишүүн нь төлөх ёстой татвараа бүрэн төлсөн, гаргасан зөрчил, алдаа дутагдлаа арилгасан, бусдад учруулсан хохирлыг бүрэн төлж барагдуулсан тохиолдолд өөрийн гишүүнчлэлийг сэргээхээр хүсэлт гаргаж болно.

ДОЛОО. НИЙГЭМЛЭГИЙН БҮТЭЦ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

- 7.1 Нийгэмлэг нь бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, хяналтын зөвлөл гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.
- 7.2 **Бүх гишүүдийн хурал**: Нийгэмлэгийн эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.
- 7.3 Бүх гишүүдийн хурал нь Нийгэмлэгийн төв салбар болон орон нутгийн салбар нийгэмлэгийн гишүүдийн хурлаас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэнэ.
- 7.4 Бүх гишүүдийн хурал нь 4 жилд нэг удаа хуралдана.
- 7.5 **Удирдах зөвлөл**: Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт Нийгэмлэгийн эрх барих байгууллага нь түүнээс сонгогдсон удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл нь нийгэмлэгийн тэргүүн бөгөөд удирдах зөвлөлийн дарга, гишүүд зэрэг 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.6 **Гүйцэтгэх захирал**: Гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Нийгэмлэгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 7.7 Гүйцэтгэх захирал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 7.7.1 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор Нийгэмлэгийг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх;
 - 7.7.2 Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний дотор хэлцэл хийх, гэрээ байгуулах, Нийгэмлэгийн өмч хөрөнгийг захиран зарцуулах;
 - 7.7.3 Гэрээнд заасан бусад эрх.
- 7.8 **Хяналтын зөвлөл**: Нийгэмлэгийн хяналтын зөвлөлийг бүх гишүүдийн хурлаас 5 хүний, салбар нийгэмлэгийн хяналтын зөвлөлийг 3 хүний бүрэлдэхүүнтэй сонгоно.
- 7.9 Нийгэмлэгийн үйл ажиллагаанд тогтмол идэвхитэй оролцдог, гишүүнээр олон жил ажилласан, 5-аас доошгүй жил гишүүний татвар төлөх үүргээ тогтмол хугацаанд нь биелүүлсэн, ажлын өндөр дадлага туршлага, ур чадвар бүхий эх баригч гишүүдээс бүх гишүүдийн хурлаар хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгоно.
- 7.10 Хяналтын зөвлөл нь дараахь үндсэн үүрэгтэй:
 - 7.10.1 Нийгэмлэг, салбар нийгэмлэгийн үйл ажиллагааны хэрэгжилт Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журам, нийгэмлэгийн дүрэмд

- нийцэж буй эсэхэд хяналт тавих, Нийгэмлэгийн бичиг баримтын бүрдэл, хөтлөлтийг хянах, заавар, зөвлөмж өгөх;
- 7.10.2 Гүйцэтгэх удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, татвар хураалт мөнгө хөрөнгө зарцуулалтын байдлыг жилд 1 удаа шалган үнэлэлт өгөх.

НАЙМ. БҮХ ГИШҮҮДИЙН ХУРЛЫН БҮРЭН ЭРХ

- 8.1 Дараахь асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 8.1.1 Нийгэмлэгийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 - 8.1.2 Нийгэмлэгийн хяналтын зөвлөлийн тайлан;
 - 8.1.3 Нийгэмлэгийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
 - 8.1.4 Нийгэмлэгийг өөрчлөн байгуулах, татан буулгах;
 - 8.1.5 Гишүүдийн татварын хэмжээг тогтоох
 - 8.1.6 Нийгэмлэгийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл болон тэргүүнийг сонгох, чөлөөлөх, нөхөн сонгох.
- 8.2 Цаг үеийн шаардлагаар асуудлыг яаралтай хэлэлцэж, шийдвэр гаргах шаардлагатай болсон бол удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар бүх гишүүдийн хурлыг хуралдуулна.
- 8.3 Бүх гишүүдийн хуралд татвараа төлсөн гишүүн нь сонгох болон сонгогдох эрх эдэлнэ.

ЕС. УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 9.1 Удирдах зөвлөл нь нийгэмлэгийн тэргүүн буюу удирдах зөвлөлийн дарга, гишүүд зэрэг 15 хүний бүрэлдэхүүнтэй байна. Удирдах зөвлөлийн дарга нь төрийн бус байгууллагыг гадаад, дотоодод төлөөлөх, удирдах зөвлөлийн хуралдааныг даргалах, удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах зэрэг бүрэн эрхтэй байна.
- 9.2 Удирдах зөвлөл нь Нийгэмлэгийн байнгын үйл ажиллагааг удирдан чиглүүлж, улирал тутам хуралдана.
- 9.3 Дараахь асуудлыг зөвхөн удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ:
- 9.3.1 Нийгэмлэгийн жил, улирлын ажлын төлөвлөгөөний явц, үр дүн;
 - 9.3.2 Нийгэмлэгийн санхүүгийн төвлөрөлт, зохицуулалт, хяналт;
 - 9.3.3 Бүх гишүүдийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтын асуудал;
 - 9.3.4 Удирдах зөвлөлийн гишүүнээс тэргүүнийг нэр дэвшүүлж, сонгоно.
 - 9.3.5 Нийгэмлэгийн жилийн төсөв батлах;
 - 9.3.6 Салбар нийгэмлэг байгуулах, бүртгэх;
 - 9.3.7 Гүйцэтгэх захирлыг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх;
 - 9.3.8 Нийгэмлэгийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоох;
 - 9.3.9 Нийгэмлэгийн ажлын албаны бүтэц, зохион байгуулалтыг батлах;
 - 9.3.10 Нийгэмлэгийн үйл ажиллагааны тулгамдсан болон цаг үеийн бусад асуудал.
- 9.4 Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг тогтоол хэлбэрээр гаргаж хэрэгжүүлэх бөгөөд гишүүн бүр саналын тэгш эрхтэй оролцоно.

- 9.5 Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зөрчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зөрчилтэй байвал хуралдааныг өөр гишүүн даргална.
- 9.6 Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зөрчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргана.
- 9.7 Удирдах зөвлөл нь шаардлагатай бол Нийгэмлэгийн ажлын алба (орон тооны гүйцэтгэх захирал, нарийн бичгийн дарга, нягтлан, сурагч, багш нар)-тай гэрээ байгуулан ажиллуулж болно.
- 9.8 Цаг үеийн шаардлагаар асуудлыг яаралтай хэлэлцэж, шийдвэр гаргах шаардлагатай болсон бол удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулна.

АРАВ. НИЙГЭМЛЭГИЙН УДИРДЛАГЫГ СОНГОХ

- 10.1 **Нийгэмлэгийн тэргүүнийг сонгох**: Нийгэмлэгийн тэргүүнийг удирдах зөвлөлөөс нэр дэвшүүлж бүх гишүүдийн хурлаар гишүүдийн олонхийн саналаар сонгоно.
- 10.2 Нийгэмлэгийн тэргүүний эрх барих хугацаа нь 4 жил байх ба энэ хугацаанд цаг зуурын болон бусад шаардлагаар өөрчлөгдвөл ээлжит болон ээлжит бус хурлаас сонгууль явуулж нөхөн сонгоно.
- 10.3 Нийгэмлэгийн үйл ажиллагаатай холбоотой ямар нэг гэрээ хэлэлцээрт нийгэмлэгийг төлөөлж тэргүүн эсхүл эрх олгосон бол гүйцэтгэх захирал гарын үсэг зурна.
- 10.4 **Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох**: Нийгэмлэгийн бүх гишүүдийн хурлаар гишүүдийн олонхийн саналаар удирдах зөвлөлийн гишүүдийг сонгоно.
- 10.5 Удирдах зөвлөлийн гишүүнээр 15 хүнийг сонгох бөгөөд тэдгээр нь эх барихуйн тусламж үйлчилгээний стандарт үйл ажиллагааг дэмжсэн, тасралтгүй сургалт, судалгаа шинжилгээ, хүн хүчний нөөц, санхүү эдийн засаг, нийгмийн чиглэлээр хариуцлага хүлээн, удирдах зөвлөлийг бүрдүүлэн ажиллана.
- 10.6 Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч дараах шаардлагыг хангасан байна:
 - 10.6.1 Эх баригч мэргэжил эзэмшсэн;
 - 10.6.2 Одоо ажиллаж байгаа байгууллагадаа 5-аас доошгүй жил ажилласан байх;
 - 10.6.3 Мэргэжлийн ахлах болон тэргүүлэх зэрэг хамгаалсан байх
 - 10.6.4 Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;
 - 10.6.5 Нийгэмлэгийн гишүүнээр 3-аас доошгүй жил идэвхтэй гишүүн байсан ба энэ хугацаанд гишүүний татвар төлөх үүргээ хугацаанд нь биелүүлсэн байх;
 - 10.6.6 Англи хэлний дунд ба түүнээс дээш түвшингийн мэдлэгтэй байх;

- 10.6.7 Компьютерийн хэрэглээний программ дээр чөлөөтэй ажилладаг байх;
- 10.6.8 Оффисын тоног төхөөрөмж, технологи эзэмшсэн байх;
- 10.6.9 Интернетийн орчинд ажиллаж чаддаг байх;
- 10.6.10 Судалгааны арга зүйд суралцсан, зохих түвшингийн мэдлэгтэй, мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн ба удирдсан туршлагатай;
- 10.6.11 Хувь хүний болон мэргэжлийн ёс зүй, хандлага төлөвшсөн.
- 10.7 **Санал хураах**: Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуулийг бүх гишүүдийн хурлаар гишүүдээс нууцаар санал хурааж, хамгийн их санал авсан гишүүнийг сонгоно.
- 10.8 Нийгэмлэгийн тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгож болно.
- 10.9 **Сонгуулийн үр дүнг хянах**: Сонгуулийн явцад бүх гишүүдийн хурлаас томилогдсон сонгуулийн комисс ажиллан саналуудыг цуглуулан:
- Зөвшөөрсөн
 - Татгалзсан
 - Хүчингүй гэж ангилан нэгтгэж, мэдээлэл хийснээр олонхийн санал авсан сонгогдогчийн нэр хүчин төгөлдөр болж батлагдана.

АРВАН НЭГ. НИЙГЭМЛЭГИЙН САНХҮҮЖИЛТ, ГИШҮҮНИЙ ТАТВАР, ТАЙЛАН

- 11.1 Нийгэмлэгийн орлогын эх үүсвэр нь гишүүдийн татвар, хандив, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, зээлийн, өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгөөс бүрдэнэ.
- 11.2 **Гишүүний татвар**: Нийгэмлэгийн гишүүний татварын хэмжээг бүх гишүүдийн хурлаас тогтооно. Гишүүн нь тогтоосон татварыг хугацаанд нь харьяа салбар хороогоороо дамжуулан Нийгэмлэгийн дансанд тушаана.
- 11.3 **Хандив**: Хуульд өөрөөр заагаагүй бол Нийгэмлэгийн дүрмийн зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Нийгэмлэгийн гишүүд, дэмжигч гишүүд, иргэд, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага болон төрийн бус байгууллагууд хандив өгч болно. Үүнд: гадаад улсын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд нэгэн адил хамаарна.
- 11.4 **Тайлан**: Нийгэмлэг нь жилийнхээ тайлан тэнцлийг дараа оны 2 дугаарсарын 15-ны дотор Татварын албанд өгнө.
- 11.5 Нийгэмлэг нь үйл ажиллагааныхаа тайланг 11.4 дэх хэсэгт заасан хугацаанд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж өгөх бөгөөд түүнд дараах асуудлыг тусгана:
- 11.5.1 Нийгэмлэгийн хаяг;
- 11.5.2 Нийгэмлэгийн үйл ажиллагааны тухай товч мэдээлэл;
- 11.5.3 Нийгэмлэгийн жилийн орлого, зарлагыг дор дурдсан ангилалаар:
- Хандивын;
 - Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны;
 - Өвлүүлсэн эд хөрөнгө;

- 11.5.4 Удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирлын нэр, хаяг.
- 11.6 Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг Нийгэмлэг нь 10-аас доошгүй жил хадгална.
- 11.7 **Хөрөнгө зарцуулалт:** Хөрөнгө санхүүгийн зарцуулалтыг Нийгэмлэгийн төв салбар дээр төвлөрүүлэн зарцуулах бөгөөд холбогдох журмыг удирдах зөвлөлийн хурлаар баталж мөрдөнө.
- 11.8 Жил бүрийн орлого зарлагыг салбар нийгэмлэг бүрээр хийж тооцно.

АРВАН ХОЁР НИЙГЭМЛЭГИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ НӨХЦӨЛ, ЖУРАМ

- 12.1 Нийгэмлэгийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу бүх гишүүдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.
- 12.2 Нийгэмлэг нь дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан эсхүл цаашид үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжгүй бодит нөхцөл байдал бий болсон бол бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.
- 12.3 Татан буулгах шийдвэр гарсны дараа Нийгэмлэгийн зохих төлбөрийг хийж, үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм төрийн бус байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.
- 12.4 Бүх гишүүдийн хурал нь Нийгэмлэгийг татан буулгасан тухай шийдвэрээ 21 хоногийн дотор нийтэд мэдээлж улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бичгээр ирүүлэх бөгөөд энэхүү шийдвэрийг үндэслэн улсын бүртгэлээс хасна.

АРВАН ГУРАВ. ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ЖУРАМ

- 13.1 Нийгэмлэгийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчилсэн найруулгын төслийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж, саналын эрхтэй нийт гишүүдийн саналын дийлэнх олонхоор батална.
- 13.2 Нийгэмлэгийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчилсэн найруулгын төслийн саналыг салбар нийгэмлэгийн дарга, нийгэмлэгийн гишүүд бичгээр, удирдах зөвлөлд өгч, хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 13.3 Нийгэмлэгийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчилсэн найруулгын санал, асуудал нь бүх гишүүдийн хурал хуралдахаас доод тал нь 12 сарын өмнө тавигдана.
- 13.4 Нийгэмлэгийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт эсхүл шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

АРВАН ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

- 14.1 Нийгэмлэг нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

АРВАН ТАВ. ҮЙЛЧЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- 15.1 Энэхүү дүрмийг батлах, түүний хүчин төгөлдөр байдал, хэрэгжүүлэлт, нэмэлт өөрчлөлт оруулах, түүний заалтууд хүчин төгөлдөр бус болох асуудал Монгол Улсын хууль тогтоомжоор зохицуулагдана.

АРВАН ЗУРГАА. БУСАД

- 16.1 Энэхүү Дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж нэг хувийг бүртгэх байгууллагад, нэг хувийг нотариат, үлдсэн нэг хувийг өөртөө хадгална. Дүрмийг англи хэлээр үйлдэж болох бөгөөд энэ тохиолдолд монгол хэл дээрх хувилбар нь хууль зүйн хувьд давуу хүчинтэй байна.
- 16.2 Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 16.3 Энэхүү Дүрэм нь Нийгэмлэгийн үндсэн баримт бичиг байна.
- 16.4 Энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

---oOo---